



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Эрүүл мэндийн суурь шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор  
ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулж, үйлчлүүлэгчид ээлтэй, ажилтнуудаа дэмжсэн байгууллагын үнэт зүйл, соёл, зан үйлийг төлөвшүүлэх, удирдах ажилтны манлайллыг хөгжүүлэх “Эрүүл мэндийн байгууллагын хөгжил” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагуудын төсөвт энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн тодорхой хэсгийг 2014 оноос эхлэн жил бүр тусгаж батлуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат), Санхүү, эдийн засгийн хэлтэс (Д.Дамдиндорж)-т, Олон улсын байгууллага, Төрийн бус байгууллагатай хамтран төсөл хэрэгжүүлэх замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр олж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга/захирлуудад үүрэг болгосугай.

3. “Эрүүл мэндийн байгууллагын хөгжил” хөтөлбөрийг салбарын хэмжээнд сурталчлах, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг), Байгууллагын удирдлага, хөгжлийн хэлтэс (Д.Оюунцэцэг)-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Ж.Хатанбаатарт үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ



Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
228 тоот тушаалын хавсралт



## “ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР

### I. Хөтөлбөр хэрэгжүүлэх нийтлэг үндэслэл:


Эрүүл мэндийн салбарын үндсэн зорилго болох хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох бодлого, хөтөлбөр, стратегийг батлан хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг жилээс жилд нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлсээр ирсэн ч хүн амын дунд эрүүл мэндийн салбарын нэр хүнд төдийлөн сайн биш, хууль, дүрэм, журам, стандарт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүн, хөрөнгө оруулалтын үр ашиг мэдэгдэхүйц эерэг үр нөлөө үзүүлэхгүй байна. Үүний нэг гол шалтгаан нь нэгж байгууллагын түвшинд эдгээрийн хэрэгжилт жигд бус, ажилтнуудад мэдээлэл дутмаг, бүх түвшинд удирдлагын манлайлал, санал санаачлага хангалттай бус, байгууллагууд үйл ажиллагааны үр дүнтэй зохион байгуулалт, стратегийг тодорхойлоогүй, байгууллагын соёл, зан үйлд анхаарал хандуулж чадаагүйтэй холбоотой.

Гэхдээ эрүүл мэндийн байгууллагуудад өөрсдийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн жижиг санал, санаачлагууд олон байгаа бөгөөд энэ нь “Байгууллагын хөгжил” гэдэг цогц асуудлын аль нэг бүрэлдэхүүн, эсвэл нэг бүрэлдэхүүн хэсгийн жижиг асуудлыг хамарч байгаагаас байгууллагын түвшинд дорвитой үр нөлөө олонхи тохиолдолд үзүүлэхгүй байж болох талтай юм. “Байгууллагын хөгжил”-ийг цогцоор нь авч үзэхийг оролдсон манай эрүүл мэндийн байгууллагуудын зарим туршлагаас дурдвал:

- Сэлэнгэ, Архангай аймгийн зарим эмнэлгүүдэд “Санта-Сюд” ТББ-ын дэмжлэгтэйгээр “Байгууллагын хөгжил” төслийг хэрэгжүүлсэн. Тухайн эмнэлгийн эмч ажилчид, аймгийн ЭМГ, орон нутгийн ЗДТГ, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, ард иргэдийн төлөөллийн оролцоотойгоор эмнэлгийн гадаад, дотоод орчны хүчин зүйлд дүн шинжилгээ хийх замаар хүн ам, эмнэлгийн эмч ажилчид болон тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад тулгарч буй




хэрэгцээ шаардлагууд, тулгамдсан асуудлыг тодорхойлж, 2009-2012 онд баримтлах байгууллагын стратегийн чиглэл, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулж байгууллага хөгжүүлэх төсөл хэрэгжүүлсэн. Гэхдээ энэ төслийн үр дүн, үр нөлөө, тогтвортой байдлыг хараахан үнэлж дүгнээгүй байгаа билээ.



- Улсын клиникийн II төв эмнэлгийн хамт олон байгууллагын тусламж үйлчилгээний чанараа сайжруулах зорилгоор Чанарын удирдлагын ISO 9001:2008, MNS ISO 9001:2010 олон улсын стандартыг нэвтрүүлж “гэрчилгээ” авсанаар эрүүл мэндийн байгууллагуудаас анх удаа дээрх стандартыг хэрэгжүүлсэн эмнэлэг болсон. Жил бүр Стандартчлал хэмжил зүйн газраас тус байгууллагад чанарын удирдлагын стандартын шалгуурыг хэрхэн хангаж байгаа талаар үнэлж, баталгаажуулалт хийдэг байна.
- Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийг дэмжих зорилгоор ЭМЯ-аас 2012 оны 11 дүгээр сард төслийн уралдаан зарлаж Архангай аймгийн ЭМГ-ын “Аймгийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасгийн тусламж үйлчилгээг сайжруулах”, Дорноговь аймгийн ЭМГ-ын “Эрүүл ажлын байр-Ээлтэй орчин”, “Асуудалд суурилсан төв” ТББ-аас ЭМШУИС-тай хамтран хэрэгжүүлэх “Үйлчлүүлэгч төвтэй эмнэлэг” төслүүдийг шалгаруулан 90 сая төгрөгийн санхүүжилт олгоод байгаа бөгөөд төслүүд хэрэгжиж байна.
- Түүнчлэн 2010 оноос ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд өөрийн байгууллагын, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд орон нутгийн эрүүл мэндийн салбарын “Стратеги төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдаар батлуулан хэрэгжүүлж байна.

“Байгууллагын хөгжил”-ийн талаар олон улсын түвшинд судалгаа, шинжилгээ хангалттай хэдий ч манай улсын хувьд ялангуяа эрүүл мэндийн салбарын түвшинд “эрүүл мэндийн байгууллагын хөгжил”-ийн талаар хийсэн судалгаа, шинжилгээ, нотолгоо хомс байна.






Эрүүл мэндийн тогтолцооны нэгж болох эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийг дэмжин, тэдгээрийн хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж байгууллагын түвшинд үйл ажиллагааны гүйцэтгэл (бүтээмж/ үр дүн/ үр ашиг)-ийг нэмэгдүүлэх нь эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх үндэс хэмээн үзэж эрүүл мэндийн байгууллагуудад “байгууллагын хөгжил”-ийн үзэл санааг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Байгууллагыг хөгжүүлнэ гэдэг нь түүний аль нэг бүрэлдэхүүн хэсэг бус тогтолцоог бүхэлд нь өөрчлөх үйл явц билээ. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн байгууллагын хөгжилд байгууллагын үнэт зүйл/ соёл (shared value/ culture), удирдлагын арга барил (management style), ажилтан, албан хаагч (staff), үйл ажиллагааны төлөвлөгөө (strategy), зохион байгуулалт (structure), үйл ажиллагаа (system) гэсэн байгууллагын дотоод бүрэлдэхүүнээс гадна байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах орц буюу нөөц (хүний нөөц, санхүүжилт, дэд бүтэц/техник, технологи), үйл ажиллагааны дүнд бий болох гарц буюу бүтээгдэхүүн, тусламж үйлчилгээний тоо, хэмжээ, чанар, хүртээмж, түүнийг хүртэж байгаа зорилтот бүлэг (хүн ам) нөлөөлнө.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, санхүүжилтийн стратеги, техник, технологийн бодлого, тусламж үйлчилгээний чанар сайжруулах хөтөлбөрүүд батлагдан, эдгээр бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөг эрүүл мэндийн байгууллага бүр өөрийн онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжүүлж байгаа тул “Эрүүл мэндийн байгууллагын хөгжил” хөтөлбөрт байгууллагын үнэт зүйл/ соёл, удирдлагын арга барил, ажилтан, албан хаагч, үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалт, үйл ажиллагаа гэсэн байгууллагын 6 дотоод бүрэлдэхүүн хэсгийг хамруулсан.

Иймд энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааг тодорхойлохдоо “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого”,





“Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр”, “Эрүүл мэндийн санхүүжилтийн стратеги” зэрэг байгууллагын менежменттэй холбоотой хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагаатай аль болох давхцуулаагүй бөгөөд харин эдгээр баримт бичгүүдэд баримталж буй чиглэлтэй нь нийцүүлэн, эрүүл мэндийн байгууллага бүрт хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг тусгахыг зорьсон.

Төрийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага бүр энэхүү хөтөлбөрийг үндэслэн өөрийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх бөгөөд байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл (бүтээмж/ үр дүн/ үр ашиг)-ийг сайжруулахыг эрмэлзэж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд мөн адил уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Байгууллагыг хөгжүүлэх буюу чадавхийг сайжруулах нь тухайн байгууллагын хамт олон, сонирхогч бусад талуудын оролцоог хангаж, урт хугацаанд үе шаттай хийгдэх бөгөөд байгууллагын гадаад, дотоод нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийг уян хатан, тасралтгүй, тогтвортой үргэлжлүүлэх шаардлагатай.

**II. Хөтөлбөрийн зорилго:**

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчдэд ээлтэй, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр дүнтэй, чирэгдэл, хүлээгдэлгүй тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхитай болгон удирдан зохион байгуулж хөгжүүлэхэд оршино.

**III. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана:**

- Бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг хамруулах
- Байгууллагын удирдах ажилтны манлайлал, дэмжлэгт удирдлагад тулгуурлах
- Эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх
- Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
- Хамт олны оролцоог хангах



- Үйлчлүүлэгчийг дээдлэх
- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг эрхэмлэх
- Чадавхийг тасралтгүй хөгжүүлэх
- Ил тод, нээлттэй байх
- Шинэ санал, санаачлагыг дэмжих



**IV. Хөтөлбөрийн зорилтууд:**

- IV.1 Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын үнэт зүйл, соёл, зан үйлийг өөрчлөх байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- IV.2 Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын стратеги, зохион байгуулалт, дотоод үйл ажиллагааг шинэчилж, байгууллагын бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог сайжруулна.
- IV.3 Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын арга барилыг шинэ шатанд гаргаж, удирдах чадварыг бүрдүүлэн, манлайллыг хөгжүүлнэ.
- IV.4 Эрүүл мэндийн байгууллага бүр хүний нөөцийн хөгжлөө хангаж, ажлын байрны стрессийг бууруулж, ажилтандаа ээлтэй орчин бүрдүүлнэ.
- IV.5 Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулж, үйлчлүүлэгчдээ дээдэлсэн дэмжлэгт орчин бүрдүүлнэ.

**V. Хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа:**

*Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын үнэт зүйл, соёл, зан үйлийг өөрчлөх, байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа:*

- Эрүүл мэндийн бүх түвшний байгууллагууд “Байгууллагын хөгжил” хөтөлбөрийг боловсруулж, хамт олноор хэлэлцүүлэн батлуулах
- Эрүүл мэндийн байгууллага бүр үнэт зүйл, эрмэлзлэл, эрхэм зорилгоо шинээр болон шинэчлэн тодорхойлж, ажилтан бүрт ухамсарлуулан ойлгуулах



- Эрүүл мэндийн байгууллагын соёл, зан үйлийг төлөвшүүлэх, угтах, лавлах, эргэх, зөвлөх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх үйл ажиллагааг стандартчилж, байгууллагын соёлын хэм хэмжээг тогтоох
- Эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод өнгө үзэмж, тав тухтай байдал, орчин нөхцөлийг сайжруулах, тэдгээрийг үнэлэх шалгууруудыг бий болгох

***Хүрэх үр дүн 1: Эрүүл мэндийн байгууллага бүр “Байгууллагын хөгжил” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ.***


***Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын стратеги, зохион байгуулалт, дотоод үйл ажиллагааг шинэчилж, байгууллагын бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог сайжруулах 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа:***

- Эрүүл мэндийн байгууллагуудад “байгууллагын оношлогоо” хийх чадавхийг сайжруулах
- Эрүүл мэндийн байгууллагуудын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, шинэчлэн боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Үндэсний төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг дэмжиж, нутагшуулах
- Тусламж үйлчилгээнд чанарын шинэ арга хэрэгсэл нэвтрүүлж, үр дүнг тооцох

***Хүрэх үр дүн 2: Эрүүл мэндийн байгууллага бүр дунд хугацааны стратеги төлөвлөгөөг шинээр болон шинэчлэн баталж, байгууллагын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна.***



**Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын арга барилыг шинэ шатанд гаргаж, удирдах чадварыг бүрдүүлэн, манлайллыг хөгжүүлэх 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа:**




- Эрүүл мэндийн байгууллагуудад удирдлагын олон улсын болон үндэсний стандартуудыг үе шаттай нэвтрүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын бие даасан байдлыг өргөжүүлэх чиглэлээр эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах
- Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд хамт олон, үйлчлүүлэгчдийн оролцоог дэмжих замаар хөндлөнгийн хяналтыг сайжруулах
- Үндэсний төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг дэмжиж, нутагшуулах
- Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын менежментийн (эрсдлийн, чанарын, гүйцэтгэлийн, байгууллагын засаглалын) ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлэх
- Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын манлайллыг хөгжүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах
- Эрүүл мэндийн удирдах ажилтны залгамж халааг бодлоготойгоор бэлтгэхийн тулд карьерийн тогтолцоог хэрэгжүүлж эрүүл мэндийн удирдах ажилтныг томилох, нөөц бүрдүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагуудад дотоод аудит хийх чадавхийг бүрдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах

**Хүрэх үр дүн 3: Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, манлайлал сайжирна.**

**Эрүүл мэндийн байгууллага бүр хүний нөөцийн хөгжлөө хангаж, ажлын байрны стрессийг бууруулж, ажилтандаа ээлтэй орчин бүрдүүлэх 4 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа:**






- Нас, мэргэжил, ур чадвар, эрх мэдлийн, үндсэн (эмнэлгийн мэргэжилтэн) болон туслах (бусад мэргэжилтэн) ажилтнуудын зохистой харьцаа бүрдүүлэх “ажиллах хүчний төлөвлөлт”-ийг эрүүл мэндийн байгууллага бүр баталж хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагад ажилтан ажилд авах, сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг үнэлэх, шагнал урамшил олгох үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нэгдсэн журам гарган, хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжигч, стрессгүй ажлын байр бүрдүүлэх
- Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, ажлын байран дээрээ хөгжих нөхцлийг бүрдүүлэх, суралцагч байгууллага болох
- Ажлын байран дээрх осол гэмтэл, халдварын эрсдлийг бүртгэх тогтолцоог нэвтрүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авах
- Эрүүл мэндийн байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт”-ыг батлуулж, мөрдүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлж, байгууллагын түвшинд нэвтрүүлэх

***Хүрэх үр дүн 4: Эрүүл мэндийн ажилтнуудын ажиллах урам зориг бүхий дэмжлэгт орчин бүрдэнэ.***

***Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, үйлчлүүлэгчдээ дээдэлсэн дэмжлэгт орчин бүрдүүлэх 5 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий чиглэл:***

- Өвчтөний эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгох
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг сайжруулахад олон улсын чиг хандлагыг нэвтрүүлэх





- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, алдааг бүртгэх мэдээллийн тогтолцоог сайжруулж, эрүүл мэндийн байгууллага бүрт бүрэн хэрэгжүүлэх
- Иргэд, үйлчлүүлэгчдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх талаар журам гарган, нийт эрүүл мэндийн байгууллагуудад мөрдүүлэх
- Эрүүл мэндийн бүх байгууллагууд, тэдгээрийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой онлайн сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн ажилтнууд, үйлчлүүлэгчдээс тогтмол авдаг болох

**Хүрэх үр дүн 5: Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа ил тод болж, үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдэнэ.**

**VI. Хэрэгжүүлэх хугацаа:** Хөтөлбөрийг 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

**VII. Удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт:**

Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн асуудлаарх зохицуулах зөвлөл ЭМЯ-ны дэргэд ажиллах бөгөөд энэхүү зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, бусад сонирхогч талуудыг татан оролцуулах чиг үүрэгтэй ажиллана.


Хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах үйл ажиллагааг ЭМЯ-ны Байгууллагын удирдлага, хөгжил хариуцсан нэгж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн тогтолцооны судалгааны алба хамтран гүйцэтгэнэ.

Аймаг, нийслэлийн ЭМГ нь өөрийн харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудад энэхүү хөтөлбөр болон түүнийг үндэслэн боловсруулсан эрүүл мэндийн байгууллага бүрийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлж ажиллана.



Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт нь:

- Урсгал санхүүжилт;
- Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө;
- Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого;
- ОУ-ын байгууллагын хандив, тусламж, хөнгөлттэй зээл;
- Төрийн бусад болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан хандив, тусламжийн хөрөнгө;
- Бусад эх үүсвэрээс бүрдэнэ.



Энэхүү хөтөлбөрийг эрүүл мэндийн байгууллага бүр өөрсдийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан зайлшгүй хэрэгжүүлэх үүрэгтэй тул байгууллагын төсөвт тодорхой санхүүжилтийг тусгах, мөн төлбөрт тусламж үйлчилгээ г.м үйл ажиллагааны орлогоос тодорхой хөрөнгийг зарцуулах шаардлагатай болох юм.

Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийг дэмжих, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, шилдэг туршлагыг нэвтрүүлэх, удирдах ажилтны чадавхийг сайжруулах зэрэг чиглэлээр ЭМЯ болон бусад эрүүл мэндийн байгууллагууд ОУ-ын байгууллагуудтай хамтарч төсөл хэрэгжүүлэх нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.


Мөн төрийн бус байгууллага, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, иргэдээс хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг авч хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

### **VIII. Хяналт-шинжилгээ, үнэлгээ:**

Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцох, зохицуулалт болон дараагийн шатны төлөвлөлт хийх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.




Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан төрийн бус байгууллага болон бусад сонирхогч талуудын оролцоог ханган хамтран гүйцэтгэнэ.



Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний жил бүрийн хэрэгжилтэд ЭМЯ-ны Байгууллагын удирдлага, хөгжил хариуцсан нэгж хяналт тавих бөгөөд явцын болон үр дүн, үр нөлөөний хяналт-шинжилгээ, үнэлгээг ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж гүйцэтгэнэ.




Шалгуур үзүүлэлт:



№	Шалгуур үзүүлэлт	Одоогийн байгаа түвшин	2016 онд хүрэх түвшин	Эх сурвалж
<b>Зорилт 1.</b> Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын үнэт зүйл, соёл, зан үйлийг өөрчлөх, байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.				
1.	"Байгууллагын хөгжил" хөтөлбөртэй эрүүл мэндийн байгууллагын тоо	0	Төрийн хэвшлийн бүх эмнэлгүүд хөтөлбөртэй болсон байна.	Судалгаагаар
<b>Зорилт 2.</b> Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын стратеги, зохион байгуулалт, дотоод үйл ажиллагааг шинэчилж, байгууллагын бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог сайжруулна.				
2.	Дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй эрүүл мэндийн байгууллагын тоо	Аймаг, нийслэлийн ЭМГ-11  ЭМЯ-ны харьяа лавлагаа төв-15	Төрийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагууд стратегитай болсон байна.	Судалгаагаар
3.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чанарын шинэ арга хэрэгсэл нэвтрүүлж, үр дүнг тооцсон эмнэлгийн тоо	Нэгдсэн мэдээлэл байхгүй	30-аас багагүй	Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо
<b>Зорилт 3.</b> Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын арга барилыг шинэ шатанд гаргаж, удирдах чадварыг бүрдүүлэн, манлайллыг хөгжүүлнэ.				
4.	Удирдлагын олон улсын болон үндэсний стандартын гэрчилгээ авсан эмнэлгийн тоо	1	Бүх лавлагаа төвүүд	Стандарт хэмжил зүйн газар
5.	Менежментийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан удирдах ажилтнуудын хувь	Нэгдсэн мэдээлэл байхгүй	Менежерийн түвшний ажилтнуудын 60-аас доошгүй хувь	Эрүүл мэндийн байгууллагуудын тайлан Эрүүл мэндийн хөгжлийн төв
<b>Зорилт 4.</b> Эрүүл мэндийн байгууллага бүр хүний нөөцийн хөгжлөө хангаж, ажлын байрны стрессийг бууруулж, ажилтандаа ээлтэй орчин бүрдүүлнэ.				
6.	Хариуцлагын даатгалд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь	Нэгдсэн мэдээлэл байхгүй	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн 70-аас доошгүй хувь	Эрүүл мэндийн хөгжлийн төв





№	Шалгуур үзүүлэлт	Одоогийн байгаа түвшин	2016 онд хүрэх түвшин	Эх сурвалж
7.	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байран дээрх осол гэмтэл, халдварт өртөлт	Нэгдсэн мэдээлэл байхгүй	Албан ёсоор бүртгэдэг болсон байна.	Эрүүл мэндийн хөгжлийн төв
8.	Гепатит В-ын вакцинд хамрагдсан ажилтнуудын хувь	Нэгдсэн мэдээлэл байхгүй	Гепатит В-ын вакцинд хамрагдах ёстой ажилтнуудын 90-ээс доошгүй хувийг хамруулсан байна.	Судалгаагаар
<b>Зорилт 5.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулж, үйлчлүүлэгчдээ дээдэлсэн дэмжлэгт орчин бүрдүүлнэ.				
9.	Эрүүл мэндийн байгууллагууд, тэдгээрийн удирдлагын үйл ажиллагааны талаарх эрүүл мэндийн ажилтнууд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь	Нэгдсэн мэдээлэл байхгүй	Сэтгэл ханамжийн түвшин 70-аас доошгүй хувьтай байна.	Эрүүл мэндийн хөгжлийн төв
10.	Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, алдааг бүртгэдэг эмнэлгийн тоо	Нэгдсэн мэдээлэл байхгүй	Бүх эмнэлгүүд бүртгэдэг болсон байна.	Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо



**IX. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ШААРДАГДАХ ТӨСӨВ:**



№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага	Хэрэг-жүүлэх хугацаа				Шаардагдах төсөв (сая төг)	Санхүүжилтийн эх үүсвэр
				2013 он	2014 он	2015 он	2016 он		
Зорилт 1. Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын үнэт зүйл, соёл, зан үйлийг өөрчлөх, байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.									
Үйл ажиллагааны чиглэл 1.1. Эрүүл мэндийн бүх түвшиний байгууллагууд “Байгууллагын хөгжил” хөтөлбөрийг боловсруулж, хэлэлцүүлэн батлуулах									
1.	Байгууллагын хөгжил хөтөлбөрийг хамт олны оролцоотойгоор боловсруулж батлах, хэрэгжүүлэх	ЭМБ-ууд	-					-	-
Үйл ажиллагааны чиглэл 1.2. Эрүүл мэндийн байгууллагын үнэт зүйл, эрмэлзлэл, эрхэм зорилгыг тодорхойлох, хэрэгжүүлэх									
2.	Байгууллагын үнэт зүйл, эрмэлзлэл, эрхэм зорилгыг хамт олноороо хэлэлцэж шинэчлэх, шинээр тодорхойлох	ЭМБ-ууд	Удирдлагын академи					-	-
3.	Ажилтан бүр өөрийн байгууллагын үнэт зүйл, эрмэлзлэл, эрхэм зорилгыг мэддэг болох аяныг зохион байгуулах	ЭМБ-ууд	Удирдлагын академи					-	-
4.	Байгууллагын түүх, үнэт зүйл, эрмэлзлэл, эрхэм зорилгыг ажилтан, үйлчлүүлэгчдэд ил тод харагдахаар байрлуулж хэвших	ЭМБ-ууд	-					10.0	Байгууллагын үйл ажиллагааны орлогоос



<b>Үйл ажиллагааны чиглэл 1.3. Эрүүл мэндийн байгууллагын соёл, зан үйлийг төлөвшүүлэх, угтах, лавлах, эргэх, зөвлөх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх үйл ажиллагааг стандартчилж, байгууллагын соёлын хэм хэмжээг тогтоох</b>						
5.	“Байгууллагын соёл”-ын сургалтыг зохион байгуулах	ЭМЯ (БУХХ) ЭМБ-ууд	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи		25.0	Төсөв, ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
6.	Байгууллага бүр шинэ ажилтнуудад байгууллагын соёл, зан үйлийн талаар таниулах сургалт зохион байгуулж хэвших	ЭМБ-ууд	-		-	-
7.	Байгууллагад “Өглөөний мэндчилгээ”-г хэвшүүлэх	ЭМБ-ууд	-		-	-
8.	Ёс зүйн хэм хэмжээнээс гадна эрүүл мэндийн байгууллагын <b>угтах, лавлах, эргэх, зөвлөх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх үйл ажиллагааны стандарт</b> удирдамжийг боловсруулан тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх	ЭМЯ (ОЭТХ, ЭТХ, ХНХХ) ЭМБ-ууд	ТББ		-	-
9.	Байгууллагын түүх, үнэт зүйл, эрхэм зорилго, соёл, үйл ажиллагааны талаар видео, бусад хэлбэрийн танилцуулгатай болох	ЭМБ-ууд	-		200.0	Байгууллагын үйл ажиллагааны орлогоос
10.	Зөвлөгөө өгөх, харилцааны ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг байгууллагууд тогтмолжуулах	ЭМБ-ууд	ТББ		-	-
11.	Байгууллага бүр үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээллийг тогтмол хүргэх цэг байгуулан ажиллуулах	ЭМБ-ууд	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, ТББ-ууд		-	-
12.	Байгууллагын хөтчийн үйл ажиллагааг өргөжүүлж, шаардлагатай үйлчлүүлэгчдийг тусламж үйлчилгээ авахад нь дагалдан явж дэмжлэг үзүүлдэг үйл ажиллагааг нэвтрүүлэх	ЭМБ-ууд	-		-	-
13.	Байгууллага бүр өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ авах ээлтэй нөхцөл бүрдүүлэхэд онцгойлон анхаарч, тэмдэг тэмдэглэгээ, зориулалтын зам, талбайг бий болгох, засч тохижуулах, шаардлагатай хөрөнгийг үе шаттай шийдвэрлэх	ЭМБ-ууд	-		-	-



14.	Байгууллага бүр ажилтан тус бүрийн харилцаа, хандлагын талаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч дүнг ажилтан, үйлчлүүлэгчдэд и тод мэдээлдэг болох	ЭМБ-ууд	-						
15.	Байгууллага бүр ажилтан тус бүрийн харилцаа, хандлагын талаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнд үндэслэн нэмэгдэл урамшууллыг ялгавартай тогтоож олгох	ЭМБ-ууд	-						
<b>Үйл ажиллагааны чиглэл 1.4. Эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод өнгө үзэмж, тав тухтай байдал, орчин нөхцөлийг сайжруулах, тэдгээрийг үнэлэх шалгууруудыг бий болгох</b>									
16.	Архи, тамхигүй орчныг бүрдүүлж, үйлчлүүлэгчид төдийгүй ойр орчинд нь үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг татан оролцуулах арга хэмжээг хэвшүүлэх	ЭМБ-ууд	-				100.0		Дэмжих сан, Байгууллагын үйл ажиллагааны орлогоос
17.	Эмнэлгийн эдэлбэр газрыг ногоон орчин болгон тохижуулах	ЭМБ-ууд	-				-		-
18.	Байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтнийг эрүүл ахуйн шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий хувцсаар хангах	ЭМБ-ууд	-				-		-
19.	Эмнэлгийн барилгын зураг, материал, гадаад, дотоод интерьерт тавигдах нэгдсэн шаардлага, шалгуурыг боловсруулж батлах	ЭМЯ (СЭЗХ, Барилга захиалагчийн алба)	-				-		-
<b>Зорилт 2. Бүх түвшинд эрүүл мэндийн байгууллагын стратеги, зохион байгуулалт, дотоод үйл ажиллагааг шинэчилж, байгууллагын бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог сайжруулна.</b>									
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.1. Эрүүл мэндийн байгууллагуудад “байгууллагын оношлогоо” хийх чадавхийг сайжруулах</b>									
20.	Байгууллагын оношлогоо хийх гарын авлага, удирдамж боловсруулж эрүүл мэндийн байгууллагуудыг хангах	ЭМЯ (БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				7.0		Дэмжих сангаас, ОУ-ын байгууллагын санхүүжилтээр



21.	Байгууллагын оношлогоо хийх чадавхийг сайжруулах цэрал сургалтуудыг зохион байгуулах	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Удирдлагын академи				25.0	Дэмжих сангаас, ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
22.	Байгууллага бүр өөрийн байгууллагын оношлогоо хийх	ЭМБ-ууд	-				-	-
23.	Эрүүл мэндийн байгууллагад оношлогоо хийхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран оролцох	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Удирдлагын академи				-	-
24.	Эрүүл мэндийн байгууллагууд дотоод бүтэц зохион байгуулалтанд байгаа чирэгдэл хүнд, суртлыг илрүүлж, өөрчлөн зохион байгуулах	Эрүүл мэндийн хөгжлийн төв	-				-	-
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.2. Эрүүл мэндийн байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, шинэчлэн боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх</b>								
25.	Байгууллагууд дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтээ үнэлэх	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				-	-
26.	Байгууллага бүр дунд хугацааны стратеги төлөвлөгөөгөө шинээр болон шинэчлэн боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Удирдлагын академи				-	-
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.3. Үндэсний төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг дэмжиж, нутагшуулах</b>								
27.	Эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг шалгаруулж, сурталчлах	ЭМЯ (БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				5.0	Дэмжих сангаас
28.	Байгууллагыг хөгжүүлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын дунд болзолт уралдаан зарлаж, дэмжлэг үзүүлэх, үр дүнг тооцох, сурталчлах	ЭМЯ (БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				20.0	Дэмжих сангаас






29.	“Байгууллагын хөгжил” сургалтыг байгууллага бүр зохион байгуулах	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи					
30.	Байгууллагуудад “5S” загварыг хэрэгжүүлэх, нэвтрүүлэх	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи					
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.4. Тусламж үйлчилгээнд чанарын шинэ арга хэрэгсэл нэвтрүүлж, үр дүнг тооцох</b>								
31.	Хувийн хэвшлийн болон төрийн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх шалгуурыг боловсруулж батлах	ЭМЯ (ХШУДАГ)	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо				5.0	Дэмжих сангаас
32.	Шалгуурын дагуу хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг тусламж үйлчилгээний чанараар нь эрэмбэлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	ЭМГ-ууд					5.0	Дэмжих сангаас
33.	Шалгуурын дагуу төрийн эрүүл мэндийн байгууллагуудыг тусламж үйлчилгээний чанараар нь эрэмбэлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	ЭМЯ (ХШУДАГ)					10.0	Дэмжих сангаас
34.	Эмнэлгийн хүлээгдэл, чирэгдэл, алдааг долоо хоног бүр хэлэлцэж, бууруулах арга хэмжээг шийдвэрлэж хэвших	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо				-	-
<b>Зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын арга барилыг шинэ шатанд гаргаж, удирдах чадварыг бүрдүүлэн, манлайллыг хөгжүүлнэ.</b>								
<b>Үйл ажиллагааны чиглэл 3.1. Эрүүл мэндийн байгууллагуудад удирдлагын олон улсын болон үндэсний стандартуудыг үе шаттай нэвтрүүлэх</b>								
35.	Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудад удирдлагын олон улсын болон үндэсний стандартуудын талаар цуврал сургалт зохион байгуулах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Стандарт хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв				60.0	Төсөв Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
36.	Эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлэх удирдлагын олон улсын болон үндэсний стандартын жагсаалтыг гаргах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Стандарт хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв				-	-

107



37.	Эрүүл мэндийн байгууллагад удирдлагын олон улсын болон үндэсний стандартуудыг нэвтрүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх	ЭМЯ (БТГ, БУХХ)	Стандарт хэмжил зүйн газар, Удирдлагын академи					30.0	Төсөв Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
38.	Эрүүл мэндийн зарим байгууллагад өмнө нэвтрүүлсэн удирдлагын олон улсын болон үндэсний стандартуудын хэрэгжилт, үр дүнг үнэлэх	ЭМЯ (ХШУДАГ БТГ, БУХХ)	Стандарт хэмжил зүйн газар, Монголын чанарын холбоо, Эрүүл мэндийн хөгжлийн төв					5.0	Дэмжих сан
39.	Удирдлагын олон улсын болон үндэсний стандартуудыг амжилттай нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, туршлага судлуулах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв					15.0	Дэмжих сан
40.	Удирдлагын олон улсын болон үндэсний стандартуудыг амжилттай нэвтрүүлсэн үндэсний компаниуд бусад төрийн байгууллагуудын туршлагыг судлах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Стандарт хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв					15.0	Дэмжих сан
<b>Үйл ажиллагааны чиглэл 3.2. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын бие даасан байдлыг өргөжүүлэх чиглэлээр эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах</b>									
41.	Эрүүл мэндийн байгууллагын удирдах зөвлөлийн эрх, үүргийн талаарх эрх зүйн баримт бичигт шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах	ЭМЯ (БТГ)	-					-	-
<b>Үйл ажиллагааны чиглэл 3.3. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд хамт олон, үйлчлүүлэгчдийн оролцоог дэмжих замаар хөндлөнгийн хяналтыг сайжруулах</b>									
42.	Байгууллагын удирдлагын түвшний нууцад хамааруулаагүйгээс бусад шийдвэрүүдийг байгууллагын ажилтнуудад ил тод хүргэх нөхцлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх	ЭМБ-ууд	-					-	-
43.	Байгууллагын үйл ажиллагааны талаар хэрэглэгчид болон ажилтнуудаас авах сэтгэл ханамжийн судалгаанд удирдлагын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тусгаж хэвших, байгууллагын дарга/захирлын гэрээг дүгнэхэд харгалзан үздэг болох	ЭМЯ (БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв					-	-





44.	Байгууллагын удирдлагууд сар бүр үйлчүүлэгчидтэй уулзалт хийж хэвших	ЭМБ-ууд	-					
45.	Итгэний эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий санал гомдлын зөвлөлийг ажиллуулах	ЭМБ-ууд	-					
46.	Үйлчлүүлэгчид, ажилтнуудын гаргасан санал, хүсэлтийн дагуу хийсэн ажлын тайланг тусгайлан гаргаж ил тод хүргэж хэвших	ЭМБ-ууд	-					

**Үйл ажиллагааны чиглэл 3.4. Үндэсний төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг дэмжиж, нутагшуулах**

47.	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг шалгаруулж, урамшуулах	ЭМЯ (БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв				20.0	Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
48.	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд сурталчлах, туршлага судлуулах	ЭМЯ (БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв				15.0	Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
49.	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын шилдэг арга барил, санаачлага, үйл ажиллагааг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	ЭМЯ (БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв				20.0	Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр

**Үйл ажиллагааны чиглэл 3.5. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын менежментийн (эрсдлийн, чанарын, гүйцэтгэлийн, байгууллагын засаглалын) ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлэх**

50.	Эрүүл мэндийн байгууллагын бүх шатны менежерүүдийг эрсдлийн, чанарын, гүйцэтгэлийн, байгууллагын засаглалын удирдлагын сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөө гаргах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				-	-
51.	Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын менежментийн сургалтын гарын авлагыг боловсруулах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				30.0	Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
52.	Удирдах ажилтнуудад зориулсан цуврал сургалтуудыг зохион байгуулах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				50.0	Төсөв ОУ-ын байгууллагын санхүүжилтээр



**Үйл ажиллагааны чиглэл 3.6. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын манлайллыг хөгжүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах**

53.	Эрүүл мэндийн байгууллагын бүх шатны менежерүүдийг манлайллын сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөө гаргах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи						
54.	Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын манлайллын сургалтын гарын авлагыг боловсруулах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				10.0		Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
55.	Удирдах ажилтнуудад зориулсан цуврал сургалтуудыг зохион байгуулах	ЭМЯ (БТГ, БУХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи				50.0		Төсөв ОУ-ын байгууллагын санхүүжилтээр

**Үйл ажиллагааны чиглэл 3.7. Эрүүл мэндийн удирдах ажилтны залгамж халааг бодлоготойгоор бэлтгэхийн тулд карьерийн тогтолцоог хэрэгжүүлж эрүүл мэндийн удирдах ажилтныг томилох**

56.	Эрүүл мэндийн байгууллагын түвшин бүрийн удирдах ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг эргэн хянаж, тавигдах шаардлагуудыг "Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн баримт бичиг"-тэй уялдуулан шинэчлэн боловсруулж, батлуулах	ЭМЯ (БУХХ, ХНХХ)	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл					-	-
57.	Эрүүл мэндийн байгууллагад янз бүрийн түвшиний удирдах ажилтныг сонгон шалгаруулах нийтлэг журмыг боловсруулж батлуулах	ЭМЯ (БУХХ, ХНХХ)	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл					-	-
58.	Нийтлэг журмыг үндэслэн байгууллага бүр удирдах ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах журмыг баталж, хэрэгжүүлэх	ЭМЯ (БУХХ, ХНХХ)	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл					-	-
59.	Удирдах ажилтныг ажилд авсан, сонгон шалгаруулсан тухай мэдээллийг байгууллагын ажилтнуудад ил тод мэдээлж хэвших	ЭМЯ (БУХХ, ХНХХ)	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл					-	-

**Үйл ажиллагааны чиглэл 3.8. Эрүүл мэндийн байгууллагуудад дотоод аудит хийх чадавхийг бүрдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах**



60.	Байгууллагуудын дотоод аудиторуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулах	ЭМЯ (ХШУДАГ)	Аудитын газар				25.0	Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
61.	Дотоод аудитын тайлангийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцож хэвших	ЭМБ-ууд	-					1
62.	Эрүүл мэндийн байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх	ЭМЯ (ХШУДАГ)	Аудитын газар					
<b>Зорилт 4. Эрүүл мэндийн байгууллага бүр хүний нөөцийн хөгжлөө хангаж, ажлын байрны стрессийг бууруулж, ажилтандаа ээлтэй орчин бүрдүүлнэ.</b>								
<b>Үйл ажиллагааны чиглэл 4.1. Нас, мэргэжил, ур чадвар, эрх мэдлийн, үндсэн болон туслах ажилтнуудын зохистой харьцаа бүрдүүлэх “ажиллах хүчний төлөвлөлт”-ийг эрүүл мэндийн байгууллага бүр баталж хэрэгжүүлэх</b>								
63.	Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн төлөвлөлт хийх чадавхийг бүрдүүлэх сургалтыг зохион байгуулах	ЭМЯ (ХНХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи, ТББ-ууд				25.0	Төсөв Дэмжих сан ОУ-ын байгууллагын санхүүжилтээр
64.	Нас, мэргэжил, ур чадвар, эрх мэдлийн, үндсэн (эмнэлгийн мэргэжилтэн) болон туслах (бусад мэргэжилтэн) ажилтнуудын зохистой харьцаа бүрдүүлэх “ажиллах хүчний төлөвлөлт”-ийг байгууллага бүр баталж хэрэгжүүлэх, жил бүр нэмэлт өөрчлөлт оруулах	ЭМЯ (ХНХХ)	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи, ТББ-ууд				-	-
<b>Үйл ажиллагааны чиглэл 4.2. Эрүүл мэндийн байгууллагад ажилтан ажилд авах, сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг үнэлэх, шагнал урамшил олгох үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нэгдсэн журам гарган, хэрэгжүүлэх</b>								
65.	Эрүүл мэндийн байгууллагад ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах нийтлэг журмыг боловсруулж батлуулах	ЭМЯ (ХНХХ)	-				-	-
66.	Нийтлэг журмыг үндэслэн байгууллага бүр ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах журмыг баталж, хэрэгжүүлэх	ЭМБ-ууд	-				-	-
67.	Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх нийтлэг журам, аргачлалыг боловсруулж батлуулах	ЭМЯ (БТГ)	-				-	-
68.	Салбарын шагналыг олгох шалгуурыг шинээр тогтоох	ЭМЯ (БУХХ)	-				-	-



69.	Ажилтныг ажилд авсан, шагнал урамшилд хамруулсан талаарх сонгон шалгаруулалтын мэдээллийг байгууллагын ажилтнуудад ил тод мэдээлж хэвших	ЭМБ-ууд	-						
<b>Үйл ажиллагааны чиглэл 4.3. Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжигч, стрессгүй ажлын байр бүрдүүлэх</b>									
70.	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөртэй уялдуулан байгууллага бүр ажилтнуудынхаа нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	ЭМБ-ууд							
71.	Байгууллага бүрт ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрт зориулсан тодорхой зардлыг төсөвт тусгаж хэвших	ЭМЯ (СЭЗХ)					-		-
72.	Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр ажилтнуудад ил тод тайлагнаж, нэмэлт, өөрчлөлт оруулах	ЭМБ-ууд					-		-
73.	Ажлын байрны үнэлгээг хийлгэж, гарсан дүгнэлтийн дагуу арга хэмжээнүүдийг үе шаттай авах	ЭМБ-ууд					50.0		Байгууллагын үйл ажиллагааны орлого
74.	Ажлын байрны стрессийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох	ЭМБ-ууд				ТББ-ууд	100.0		Байгууллагын үйл ажиллагааны орлого ОУ-ын байгууллагын санхүүжилт
75.	Эрүүл мэндийн ажилтан бүр архи, тамхинаас татгалзаж, архи, тамхигүй орчин болох амлалт авч хэрэгжүүлэх аяныг үндэсний хэмжээнд өрнүүлэх, урамшуулах	ЭМБ-ууд					-		-
76.	Байгууллагын ахмад ажилтнуудтай тогтмол уулзах, ахуй амьдралд нь дэмжлэг үзүүлэх, Дэлхийн эмч нарын өдрөөр тэдэнд зориулсан арга хэмжээ зохион байгуулж хэвших	ЭМБ-ууд					-		-



208





77.	Жил бүрийн 3 дугаар сарын 18-нд ажилтнуудын гэр бүлийнхнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг хэвшүүлэх	ЭМБ-ууд	-						
<b>Үйл ажиллагааны чиглэл 4.4. Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, ажлын байран дээрээ хөгжих нөхцлийг бүрдүүлэх, суралцагч байгууллага болох</b>									
78.	Эрүүл мэндийн байгууллагуудад шинэ ажилтныг ажлын байран дээр нь дадлагажуулах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн хөгжлийн төв						
79.	Эмнэлгийн мэргэжилтэн бүрийг 5 жилд нэг удаа байгууллагын болон төрийн сангийн хөрөнгөөр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх, жил бүр нэмэлт, өөрчлөлт оруулах	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн хөгжлийн төв				-	-	
80.	Ажилтнуудын сургалтын хэрэгцээнд үндэслэж ажлын байран дээрх сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх	ЭМБ-ууд	-				-	-	
81.	Эрүүл мэндийн байгууллагын ажлын байран дээрх сургалтын чанар, үр дүнд үнэлгээ хийх	Эрүүл мэндийн хөгжлийн төв	ТББ				-	-	
82.	Гадаад сургалтанд хамрагдсан ажилтан бүр байгууллагадаа шинэлэг санаа, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг туршлагыг нэвтрүүлж хэвших	ЭМБ-ууд	-				-	-	
<b>Үйл ажиллагааны чиглэл 4.5. Ажлын байран дээрх осол гэмтэл, халдварын эрсдлийг бүртгэх тогтолцоог нэвтрүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авах</b>									
83.	Эмнэлгийн мэргэжилтний ажлын байран дээрх осол гэмтэл, эрсдлийн байдалд үнэлгээ өгөх	ЭМЯ (ХНХХ, НЭМХ)	Судалгааны байгууллагууд				10.0	Дэмжих сан	
84.	Ажлын байран дээрх осол гэмтэл, халдварын эрсдлийг бүртгэх журмыг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх	ЭМЯ (ХНХХ, НЭМХ)	Хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн ажилтнуудын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо				-	-	





85.	Ажлын байран дээрх осол гэмтэл, халдварын эрсдлээс сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	ЭМХХТ	Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын төв				5.0	Дэмжих сан
86.	Ажлын байран дээрх осол гэмтэл, халдварын эрсдлийг бүртгэх журмын хэрэгжилтийг үнэлэх	ЭМЯ (ХШУДАГ)	Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын төв				5.0	Дэмжих сан
87.	Шинээр ажилд орсон, Гепатит В-ын халдвар аваагүй мэргэжилтэн бүрийг вакцинд хамруулж хэвших	ЭМБ-ууд	Халдварт өвчин судлалын үндэсний төв					

**Үйл ажиллагааны чиглэл 4.6. Эрүүл мэндийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг батлуулж, мөрдүүлэх**

88.	Эрүүл мэндийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг боловсруулж, батлуулах	ЭМЯ (НЭМХ)	Хөдөлмөрийн яам, Стандарт хэмжил зүйнгазар				5.0	Дэмжих сан
89.	Эрүүл мэндийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын сургалтуудыг зохион байгуулах	ЭМЯ (НЭМХ, ХНХХ)					25.0	Төсөв Дэмжих сан
90.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөхтэй холбоотой дүрэм журмуудыг байгууллагын түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх	ЭМБ-ууд					-	-


**Үйл ажиллагааны чиглэл 4.7. Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлж, байгууллагын түвшинд нэвтрүүлэх**

91.	Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын хуулийг боловсруулж батлуулах	ЭМЯ (ХНХХ)	Ёс зүйн хороо, салбар хороод				-	-
92.	Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын хуулийг сурталчлах	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Ёс зүйн хороо, салбар хороод				-	-
93.	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг хариуцлагын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах	ЭМБ-ууд	Төрийн болон хувийн даатгалын байгууллагууд				-	-

**Зорилт 5. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, үйлчлүүлэгчдээ дээдэлсэн дэмжлэгт орчин бүрдүүлнэ.**

2021





<b>Үйл ажиллагааны чиглэл 5.1. Өвчтөний эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгох</b>						
94.	Өвчтөний эрхийг тодорхойлсон эрх зүйн орчныг бүрдүүлэх	ЭМЯ (БТГ, БХЗГ, ТЗУГ)	Хүний эрхийн үндэсний комисс			
95.	Өвчтөний эрхийн талаарх мэдээлэл сургалт сурталчилгааг өргөн хүрээнд зохион байгуулах	ЭМЯ (БТГ, БХЗГ, ТЗУГ)	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо		5.0	ОУ-ын байгууллагын санхүүжилт Дэмжих сан
<b>Үйл ажиллагааны чиглэл 5.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг сайжруулахад олон улсын чиг хандлагыг нэвтрүүлэх</b>						
96.	Эмнэлэгт ёс зүйн эвлэрүүлэн зуучлагч ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	ЭМЯ (ХНХХ)	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо			-
97.	Эвлэрүүлэн зуучлагчийн сургалтыг зохион байгуулах	ЭМЯ (ХНХХ)	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо			25.0 Дэмжих сан
98.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн олон улсын чиг хандлагыг судлах	ЭМЯ (ХНХХ)	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо			-
<b>Үйл ажиллагааны чиглэл 5.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, алдааг бүртгэх мэдээллийн тогтолцоог сайжруулж, эрүүл мэндийн байгууллага бүрт бүрэн хэрэгжүүлэх</b>						
99.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, алдааг бүртгэх арга аргачлал, журмыг шинэлэн боловсруулж, батлах	ЭМЯ (ЭТХ)	Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо			-
100.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, алдааг бүртгэх арга аргачлалын талаар сургалт зохион байгуулах	ЭМЯ (ЭТХ)	Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо			25.0 Дэмжих сан Төсөв
<b>Үйл ажиллагааны чиглэл 5.4. Иргэд, үйлчлүүлэгчдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх талаар журам гарган, нийт эрүүл мэндийн байгууллагуудад мөрдүүлэх</b>						
101.	Эрүүл мэндийн шуурхай удирдлагын төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	ЭМЯ (ЭТХ)	ОУ-ын байгууллага			-

205



102.	Эрүүл мэндийн салбар дах өргөдөл, гомдлын төрөл, тэдгээрийн шийдвэрлэлтийн байдалд үнэлгээ хийх	Эрүүл мэндийн хөгжлийн төв	-						4.0	ОУ-ын байгууллагын санхүүжилт
103.	Үнэлгээний дүнд үндэслэн иргэд, үйлчлүүлэгчдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлсэн журмыг боловсруулж батлах, мөрдүүлэх	ЭМЯ (БУХХ)	-							
<b>Үйл ажиллагааны чиглэл 5.5. Эрүүл мэндийн бүх байгууллагууд, тэдгээрийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой онлайн сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн ажилтнууд, үйлчлүүлэгчдээс тогтмол авдаг болох</b>										
104.	Эрүүл мэндийн яамны цахим хуудсаар эсвэл хамгийн олон хэрэглэгчтэй цахим хуудсаар эрүүл мэндийн байгууллагуудын болон удирдлагын үйл ажиллагаатай холбоотой онлайн сэтгэл ханамжийн судалгааг авах, үнэлж дүгнэх арга аргачлал, журмыг боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн хөгжлийн төв	-						-	-
105.	Батлагдсан арга аргачлалын дагуу онлайн сэтгэл ханамжийн судалгааг авч, байгууллагууд холбогдох арга хэмжээг авч хэвших	Эрүүл мэндийн хөгжлийн төв	-						-	-

Тайлбар: Төсөвт тодорхой зардлууд тусгагддаг (Тухайлбал: төгсөлтийн дараах давтан сургалт, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын ажлын хувцас г.м ) болон санхүүжилт нь шийдвэрлэгдээд одоо хийгдэж байгаа (эрүүл мэндийн байгууллагын угтах, лавлах, эргэх, зөвлөх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх үйл ажиллагааны стандарт удирдамжийг боловсруулах, шуурхай удирдлагын төв байгуулах г.м) арга хэмжээний зардлыг шаардагдах төсөвт оруулаагүй болно.